



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 5 сарын 23 өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Төлөөлөгчийн газрыг бүртгэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгалын хохирол үнэлэгч “Ашид билгүүн” ХХК-д Хөвсгөл аймгийн Мөрөн сум, 7-р хороо, 44-р байр, 102 тоотод нэг, Өвөрхангай аймгийн Арвайхээр сум, 5-р баг, Хууль зүйн үйлчилгээний төвийн байр, 301 тоотод нэг, Архангай аймгийн Эрдэнэбулган сум, 3-р баг, “Маамуу” төвийн байранд нэг, Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хайрхан баг, “Энхдэлгэр говь” гаалийн хяналтын талбайн байранд нэг нийт дөрвөн төлөөлөгчийн газар нээснийг бүртгэсүгэй.

2. Төлөөлөгчийн газар нээх болсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Хороонд ирүүлэхийг “Ашид билгүүн” ХХК /Ч.Жамъян/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН